



ХЭНТИЙ АЙМАГ
БОР-ӨНДӨР СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 02 сарын 05 өдөр

Дугаар 02

Бор-Өндөр

ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ ХАРААТ
БУС ГИШҮҮНЭЭР ОРОЛЦОХ
ИРГЭНИЙГ ТОМИЛОХ ТУХАЙ

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэр нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.5 дэх заалт, Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/254 дугаар тушаалыг тус тус үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны үнэлгээний хороонд хараат бус гишүүнээр Баатарын Эрдэнэзул, Шийлэгийн Гангэрэл нарыг томилсугай.

2. Бор-Өндөр суманд төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомж, зохих журмын дагуу зохион байгуулж, үнэлгээний хороонд энэхүү тогтоолоор томилсон иргэнийг томилгоожуулж ажиллахыг Бор-Өндөр сумын Засаг дарга /Г.Адъяабилэгт/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Э.МӨНХ-ЭРДЭНЭ